

БАТЛАВ.



БАТЛАВ.



ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д зааснаар Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн нь иргэдийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан дээрх эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт¹-ийн агуулга, үзэл санаанд нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхийг буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохыг Засгийн газарт даалгасан. Мөн тогтоолын хавсралтын 1.1.3-т “сангийн хөрөнгийн удирдлагын компани уг сангийн хөрөнгийн удирдлагыг хараат бусаар бие даан хэрэгжүүлэх, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх” гэж, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох”-ыг тус тус даалгасны хүрээнд Шилэн дансны тухай хуулийг шинэчлэн найруулах замаар олон нийтийн хяналтын зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүсээд байна.

¹ 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулсан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар бүлгийн 3.1.12-т “Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ” гэж заасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа өргөжин тэлж, улмаар нийгмийн хөгжлийг даган тухайн харилцааг зохицуулах хууль тогтоомжууд шинэчлэгдэх үйл явц үргэлжилсээр байна. Түүнчлэн мэдээллийн технологийн дэвшлийг даган иргэдийн мэдээлэл авах эх сурвалж, боломж ихээр нэмэгдсэн. Эдгээр хүчин зүйлсийн улмаас Шилэн дансны тухай хууль нь эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэрэгцээ шаардлагаас хоцорч байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр тогтоогдож, хуульд шинэчлэл хийх дараах шаардлагыг бий болгож байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль батлагдсанаас хойш Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллага гэх ойлголтыг нийтийн эрх зүйн этгээд хэмээн тодорхойлсон. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, мөн зүйлийн 3.1.2-т “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэж нэг хуулийн этгээдийг хоёр тусдаа заалтаар давхардуулан заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцэхгүй байна. Энэ нь хууль хэрэгжүүлэгч тухайн байгууллага хуулийн аль заалтад хамаарч мэдээлэл байршуулах талаар зөрүүтэй ойлголтыг бий болгож байна. Иймээс Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах этгээдийг хууль хоорондын нийцлийг хангахуйц байхаар ангилж, тодорхойлох зайлшгүй шаардлага үүсэж байна.

- Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1-д Нийгмийн даатгалын санг Засгийн газрын тусгай сангийн бүрэлдэхүүн хэсгээс салангид авч үзсэн нь хуулийн давхардлыг бий болгоод зогсохгүй мэдээлэл давхардуулан байршуулах үр дагаврыг бий болгож байна.

- Хуулийн 6 дугаар зүйлд заасан тогтмол мэдээлж байх мэдээллүүд нь агуулгын хувьд давхардсан, албан тушаалтан нэг мэдээллийг хэд хэдэн удаа байршуулж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

- Хуульд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүгийн мэдээллийг нээлттэй байршуулахаар хязгаарлалт тогтоосон нь төрийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байна.

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгахдаа төрийн өмчит үйлдвэрийн газарт хэрэгжүүлэх хяналтыг орхигдуулан томьёолсон нь хуулийн хэрэгжилтийг сулруулж байна.

- Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй, хөдөлмөрийн гэрээ, контрактын хүрээнд ажиллаж буй Шилэн дансны тухай хуулийн дагуу үүрэг хүлээсэн бусад этгээдэд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсан нь хуулийг сахин биелүүлэхгүй байх үр дагаврыг бий болгож байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг үндэслэн хуулийн үйлчлэх хүрээг сайжруулах, зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хүчингүй болгох, шинээр зүйл, заалт оруулах зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

1.Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг оновчтой тодорхойлох, шилэн дансанд байршуулах үйл ажиллагаа, мэдээллийн цар хүрээг оновчтой болгон өөрчлөлт оруулах, шилэн дансанд байршуулж буй мэдээллийн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэсгийг холбогдох бусад хууль тогтоомжийн зохицуулалтад нийцүүлэн боловсронгуй болгон тусгахаар;

2.Хоёрдугаар бүлэгт мэдээлэл хүргэх хэлбэр, шилэн дансанд байршуулах мэдээлэл, хугацаа, мэдээлэх албан тушаалтан зэргийг оновчтой болгон тодорхойлж өөрчлөлт оруулахаар;

3.Гуравдугаар бүлэгт хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох өөрчлөлтийг тус тус оруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн зорилтыг оновчтой болгон тодорхойлсноор анх хууль батлах болсон үзэл баримтлал бүрэн гүйцэд хангагдах нөхцөл бүрдэх бөгөөд хуулийн бусад зүйл, хэсэг, заалтын хэрэглээний ойлголт бүрэн гүйцэд болж дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах мэдээлэл болон түүнийг байршуулах этгээдийг давхардалгүйгээр оновчтой болгож тодорхойлно. Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах этгээд(хуулийн этгээдийн төрөл, хэлбэр)-ийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн тодорхойлсноор хууль хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн субъект, тэдгээрийн байршуулах мэдээлэл, эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон нэр томъёоны ойлголтын зөрүү арилна;

2.Байршуулах мэдээллийн давхардал арилж, ажлын ачаалал буурч, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахуйц баталгааг бүрдүүлнэ. Хуульд заасан шилэн дансны мэдээллийн цар хүрээ, мэдээлэл байршуулах хугацаа, давтамж илүү оновчтой болж төсөв, санхүүгийн талаар олон нийт мэдээлэл хайх, хүлээн авахад хялбар, ойлгомжтой болно. Мөн нэг мэдээллийг олон байгууллага тайлагнадаг чиг үүргийн давхардлыг арилгаснаар хууль хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтнуудын ажлын ачаалал багасаж, зардал буурна;

3.Хяналт, хариуцлагын тогтолцоо иж бүрэн болно. Хууль хэрэгжүүлэгч бүх байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хийхээр хуульд нэмэлт оруулснаар хууль хэрэгжүүлэхэд гарч болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэс болно;

4.Хариуцлагын тогтолцоог бүрэн гүйцэд томъёолж хуульчилснаар төсвийн сахилга батыг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна. Уг хуулийн төсөлтэй уялдуулан одоогийн мөрдөгдөж байгаа Шилэн дансны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулахаас гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах бөгөөд хуулийн төсөл боловсруулах явцад зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

---oOo---